



1990 оны 05 сарын

БНМАУ

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

дугаар 65

Улаанбаатар хот

Гандантэгчилэн хийд-хүрээ байгуулах ажлыг зохион байгуулах тухай

Гандантэгчилэн хийд, түүний орчныг тохижуулах шаардлага болон Ганданд ардын гар урлалын хэтхон байгуулах талаар соёл урлагийн зарим зүтгэлтийн гаргасан санал, Монголын архитекторчдын эвлэлийн "Архитектур" нэгдэлд боловсруулсан зураг төсөл, загварыг хэлэлцээд Гандантэгчилэн хийд-хүрээг зохион байгуулах нь манай ард түмний хот хүрэагээ байгуулж ирсэн түүхэн уламжлалыг сайтар судалж, түүний үндсэн онцлогийг орчин үеийн хот байгуулалтын зарчмтай зөв хослуулж ардын гар урлалын сонгодог арга барилыг судлах, түүнээс суралцаж, өвлүүлэн үлдээх нөхцөл бурдүүлэх гол зорилт агуулж байгааг тэмдэглээд Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Соёл урлагийн зүтгэлтэн хэсэг хүмүүсээс болон Гандантэгчилэн хийдийн захиргаа, сүсэгтэн олноос гаргасан саналыг сайшаш дэмжиж Гандангийн дэнж дээр "Гандантэгчилэн хийд-хүрээ"-г байгуулах нь зүйтэй гэж узсугэй.

2. Гандантэгчилэн хийд-хүрээ байгуулах өрөнхий төлөвлөгөөний зургийн даалгаврыг хавсралтын цагуу баталсугай.


3. Уг хүрээний өрөнхий төлөвлөгөө, архитектурын жижиг чимэглэлийн зураг төсөл боловсруулах МАЭ, МУЭ-ийн архитектор, уран бүтээлчдэд 6 дугаар сарын I-ний дотор багтаан ажлын байр гаргаж өгөхийг АДХ-ын гүйцэтгэх захиргааны орлогч дарга /н. Найдан/-д даалгасугай.

4. Гандантэгчилэн хийд-хүрээний өрөнхий төлөвлөгөөний захиалагчаар орон тооны нэг архитекторыг зураг, хайгуулын ажлын төс-

2.

вөөс цалинжуулж ажиллуулахыг Архитектур төлөвлөлтийн газар /н.Жадамбаа/-т даалгасугай.

УЛААНДААТАР ХОТЫН АРЧИН ЦИҮНТАТУУДЫН
ХҮЧИН ГҮҮСТГЭХ ЗАХИРГААНЫ
ДАРГА  Л.ЗЭЙНИ

УЛААНДААТАР ХОТЫН АЛХ-ЫН ГҮҮСТГЭХ
ЗАХИРГААНЫ ХАРИУЦАГАТАЙ НАРИН
ДИЧИЙН ДАРГА  Д.АЛГМА

